
ДУЛААН ШИЙДЭЛ 2 ТӨСЛИЙН НЭЭЛТ БОЛЛОО





Монгол Улсын хэмжээнд, тэр дундаа нийслэл Улаанбаатар хотод агаарын бохирдол нэн тулгамдсан асуудал ба Монгол Улсын Засгийн газар агаарын бохирдлыг гамшгийн хэмжээнд хүрснийг 2017 онд зарлажээ. Агаарын бохирдлыг бууруулахад гэр хороололд амьдарч буй иргэдийн хувийн сууцны дулаан алдагдлыг багасгах нь нэн чухал бөгөөд энэ хүрээнд Европын Холбооны Свич-Эшиа хөтөлбөрийн санхүүжилттэй Дулаан Шийдэл төсөл 2018-2022 онд хэрэгжиж,

нийт 1,546 айл өрх эрчим хүчний хэмнэлттэй дулаалгын шийдлүүдийг хэрэгжүүлж, нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 3,556 тонноор бууруулжээ.

Тэгвэл тус төслийн хоёрдугаар үе шат болох Дулаан Шийдэл-2 төсөл нь Европын Холбооны Свич-Эшиа хөтөлбөр, Абби Пиер сан, ГАГГА сан болон Францийн хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр хувийн сууцны салбар дахь тогтвортой хэрэглээ ба үйлдвэрлэл руу чиглэсэн бодлогыг дэмжих, Монголын нөхцөлд нийцсэн, үр ашигтай эрчим хүчний шийдлүүдийг боловсруулан нэвтрүүлэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмрээ оруулах болон эрүүл мэнд, эдийн засаг, нийгмийн хувьд үр ашигтай байх зах зээлийг бий болгох зорилго доор 2022 хэрэгжиж эхэллээ.

Арванхоёрдугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдах нээлтийн үйл ажиллагааны үеэр төслийн хүрээнд хийгдэж буй ажил, хүлээгдэж буй үр дүн, цаашдын алхмуудыг хэлэлцэж, гарын доорх материал ашиглан хямд, хялбар аргаар байшингаа дулаалах Хялбар Шийдэл аяны хүрээнд эрчим хүчний хэмнэлттэй шийдэл хэрэгжүүлсэн айл өрхүүдтэй танилцах бөгөөд Барилга хот байгуулалтын яам, Байгал орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Элчин сайдын яам, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, олон улсын байгууллагын төлөөлөл оролцоно.

Дулаан Шийдэл-2 төсөл нь дөрвөн жилийн хугацаанд нийт 5,900 айл өрхийг дулаалах, 160 БЖДБ эрхлэгчдийг чадавхжуулах, нүүрсхүчлийн хийн ялгарлыг 17,700 тонноор бууруулах зорилготой ба төслийг Жэрэс ОУТББ, ШУТИС-ийн дэргэдэх Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв, Монголын Барилгын үндэсний ассоциаци ТББ, Монголын Ногоон Санхүүгийн Корпорац, Монголын Эмэгтэйчүүдийн Сан хамтран хэрэгжүүлж байна.